



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 26 өдөр

Дугаар А/272

Мандалговь

Газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай

Монгол улсын Газрын тухай хуулийн 38 дугаар зүйл 38.1,2,4 дэх заалт, газар эзэмших эрхийг шилжүүлэн авах аж ахуй нэгжийн хүсэлтийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

Нэг. Сайнцагаан сумын төвийн 7 дугаар багийн нутаг дэвсгэр (Төв халхын дуулалт, жүжгийн театрын баруун талд)-т байршилтай Чагнаадорж овогтой Болдбаатар (ЗЮ:80011191)-ын орон сууцны зориулалттай 900 м.кв (0,09га) газрыг “Даадаа групп” ХХК (РД:6275869)-д зориулалтаар нь шилжүүлж 14 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

Хоёр. Дээрх аж ахуй нэгжтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), мөн гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт, Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч (Р.Мөнхтогтох), аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат) нарт үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2018 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн А/155 дугаар захирамжийн иргэн Ч.Болдбаатар-т холбогдох хэсэг мөн газар эзэмших 000712102 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

43121760